

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сэрээтэр	Дугаар	L265
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Бүрэн сум
Төрсөн газар	Бүрэн сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	ИТХ-ын дарга		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Салаагийн жас	Сүм хийдийн дугаар	ТӨБҮ 009
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 10-рсарын 18	Ярилцлага авсан хүн	Мөнхбат

Төв аймгийн Бүрэн сумын Салаагийн жас

Мөнхбат: Тэгэхээр энэ Бүрэн сумын төвд байсан Салаагийн жасын тухай хэдэн ламтай байсан, хичнээн ламтай ямар хурал байсан, бурхан шашны ямар үйл ажиллагаа голчлон явуулдаг байсан талаар өвөг дээдсээсээ сонсож дуулсан өвлөгдөж ирсэн, ийм мэдээлэл байвал бидэнтэй хуваалцана уу?

Сэрээтэр: Манай суманд бол хоёр хийд байсан. Нэг нь бол Төхөмийн хийд гэж нэрлэгдэх Шадавдаржаалин хийд гэж. Энэ нь бол одоо сэргээгдээд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Нэг нь бол Салаагийн жас гэж. За энэ нь бол манай өвгөд дээдэс ярихдаа бол Салаагийн хийд бол 60 гаруй ламтай ийм томоохон хийд байсан гэж ярьдаг юм. Ер нь бол Өнжүүл, Бүрэнгийнхэн, одоо Салаагийн хийд, Шороотын хийд энэ Төхөмийн хийд дээр л гол мөргөлөө хийж байсан. Тухайн үед бол нарийн үзэж судалсан юм байдаг л байх. Энэ талаар бол би ийм л юм мэддэг юм аа.

Мөнхбат: Тэгэхээр Салаагийн хурал дээр багадаа шавилан сууж байгаад хар болсон одоо амьд сэрүүн энэ Бүрэн сумын уугуул өндөр настай хүн байна уу, хот хүрээгээр байна уу, таньд одоо мэдэж дуулсан юм байна уу? Бүгд хорвоогийн жамаар байхгүй болсон байдаг юм болов уу?

Сэрээтэр: Ер нь Салаагийн хийд дээр сууж байсан лам нарыг би сайн мэдэхгүй. Ер нь энэ манай Бүрэн Өнжүүл чиглэлийн лам нар бол Баруун хүрээнд сууж байсан. Салаагийн хийдийн лам нарын тухай би сайн мэдэхгүй. Ер нь энэ талаар манай Лувсанбат гэж Гандан хийд дээр байдаг, тэр хүн нэлээн мэдээлэл өгөх байх. Бид нар бол сайн юм мэдэхгүй ээ. Та нар яахав сураад очвол Гандан дээр тэр хүн нэлээн мэдээлэл өгөх байх.

Мөнхбат: Энэ хийдийн одоо дуган байгууламжийг 1937 онд тэр лам нарыг нь бариад устгасан байдаг юм болов уу, тавьжараад оны нүүрийг үзсэн байдаг юм болов уу? Энэ талаар танд сонссон юм байна уу?

Сэрээтэр: Ер нь бол хийд нь ухаандаа би 1955 он гэхэд би суманд бага сургуульд орсон. Тэгэхэд байж байсан. Аа нурууг нь аваад сумын контор оруулсан, клуб оруулсан ийм л барилгууд байсан. Аа сүүлдээ тэрний түүхийгаар энд байгаа ХБА гэж тэрнийг бариулсан. Яг тухайн үедээ устгаад шатаачихсан юм байхгүй. Эзгүйрчихээд л байгаад

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байсан.Сүүлдээ тэр сүм нурууг нь аваад, одоо орос ч гэдэг юм уу ийм байшингийн нуруу хйигээд тэгж л байсан л даа.Тэгээд тэрний орчим лам нарын башйингууд нь байдаг тэр лам нарын байшингуудаас нь нөгөө Түвд ном, Оросын нөгөө мөнгө байдаг ш дээ.Тийм мөнгөнүүд л учиргүй тарж салхинд хийссэн. Ном судар нь тэр сүүлд байшинг нь хүн буулгахад л тарсан. Тэр нэг гүн худаг ч байдаг. Тийшээ заримыг нь хийж дарсан, дарагдсан.Тиймэрхүү л юмыг нь би мэдэх юм байна.Арга байхгүй л Төхөмийн хийд гэдэг бол том хийд байсан юм билээ, одоо бодоход.

Мөнхбат: За баярлалаа.